



## НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбаатар энержи ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/136/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх Аудитор Г.Нандинжаргал Утас: 7000-7734 Цахим хаяг: <a href="mailto:nandinjargalg@audit.gov.mn">nandinjargalg@audit.gov.mn</a> Санхүүгийн аудитхариуцсан
Улаанбаатар хот 2026 он	Ахлах менежер Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:otgonbayarda@audit.gov.mn">otgonbayarda@audit.gov.mn</a> Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ари файнэнс аудит ХХК-ийн захирал: Д.Ариунаа Утас: 99088151 Цахим хаяг: <a href="mailto:arifin.audit@gmail.com">arifin.audit@gmail.com</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.13 № 739  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

УЛААНБААТАР ЭНЕРЖИ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
С.ХҮРЭЛСҮХ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар энержи ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Нийслэлийн засаг даргын 2025 оны А/1844 дүгээр захирамжаар Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр хэрэгжүүлсэн Багануур дүүрэг дэх "Багануур Батерей хуримтлуурын станцын 220/\*110/35 кВ-ын дэд станцын 110кВ-ын хуваарилах байгууламжийн өргөтгөл, 110/35 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/35 кВ-ын дэд станц, 50 МВт-ын хүчин чадалтай 200 МВт.цагийн багтаамж бүхий 286,141.0 сая төгрөгийн өртөгтэй эрчим хүчний хуримтлуурын станцын барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг тайлант онд хөрөнгөөр бүртгэж авсан байна.

### Аудитын гол асуудал

Тус станц нь 2025 онд 75.9 МВт.цаг цахилгаан эрчим хүч хуримтлуулж, 65.7 сая цаг цахилгаан эрчим хүчийг нийлүүлж ажилласан байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

1426050713  
C:\Users\naranga\Documents\Бичиг хэргийн хэргийн 2025\2025\1426050713\1426050713.docx

### **Бусад асуудлын хэсэг**

Компанийн удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. 2025 онд өдөр бүрийн худалдан авсан, худалдсан цахилгаан эрчим хүчинд тоолуураар хяналт тавих үүднээс өөрийн эзэмшлийн оруулгын тоолуур болон арилжааны тоолуурын заалтыг авч google sheet дээр оруулснаар станцын удирдлагууд цаг тухай бүр шаардлагатай мэдээ, мэдээлэлтэй танилцан баланс харах, хяналт тавьж ажиллах боломжоор хангагдсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		01 сарын 01	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	14,399,944.10	3,519,793,579.32
1.1.02	Дансны авлага	0.00	6,246,058,167.76
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	1,035,540.39	181,619,847.89
1.1.04	Бусад авлага	0.00	393,249.15
1.1.06	Бараа материал	4,461,500.00	36,019,882.83
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	0.00	126,333.80
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>19,896,984.49</b>	<b>9,984,011,060.75</b>
1.2.01	Үндсэн хөрөнгө	0.00	274,632,300,834.21
1.2.02	Биет бус хөрөнгө	0.00	6,244,166.68
1.2.06	Хойшлогдсон татварын хөрөнгө	277,199.28	1,200,397,594.65
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>277,199.28</b>	<b>275,838,942,595.54</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>20,174,183.77</b>	<b>285,822,953,656.29</b>
2.1.1.01	Дансны өглөг	53,451,807.05	2,241,441,256.32
2.1.1.03	Татварын өр	1,878,573.64	0.00
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>55,330,380.69</b>	<b>2,241,441,256.32</b>
2.1.2.01	Урт хугацаат зээл	0.00	284,007,615,818.19
<b>2.1.2.06</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>0.00</b>	<b>284,007,615,818.19</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>55,330,380.69</b>	<b>286,249,057,074.51</b>
2.3.01	Өмч: - төрийн	100,000.00	100,000.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(35,256,196.92)	(426,203,418.22)
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	(390,947,221.30)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(35,256,196.92)	(35,256,196.92)
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>(35,156,196.92)</b>	<b>(426,103,418.22)</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>20,174,183.77</b>	<b>285,822,953,656.29</b>

Улаанбаатар энерги ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	0.00	37,863,738,137.09
02	Борлуулалтын өртөг	0.00	18,488,161,905.56
03	Нийт ашиг( алдагдал)	0.00	19,375,576,231.53
04	Түрээсийн орлого	0.00	0.00
05	Хүүний орлого	0.00	578,104,472.66
06	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
07	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
08	Бусад орлого	0.00	60,507.05
08.1	Орлогын дүн	0.00	578,164,979.71
09	Борлуулалт, маркетингийн зардал	13,782,206.56	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	15,914,181.81	352,115,625.08
11	Санхүүгийн зардал	0.00	20,856,603,753.11
12	Бусад зардал	0.00	304,811,888.89
<b>12.1</b>	<b>Зардлын дүн</b>	<b>29,696,388.37</b>	<b>21,513,531,267.08</b>
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	26,532,886.38
17.1	Олз, гарзын дүн	0.00	26,532,886.38
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)</b>	<b>(29,696,388.37)</b>	<b>(1,533,257,169.46)</b>
19	Орлогын татварын зардал	277,199.28	(1,142,309,948.16)
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(29,419,189.09)</b>	<b>(390,947,221.30)</b>
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	0.00	0.00
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>(29,419,189.09)</b>	<b>(390,947,221.30)</b>

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
09	2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	100,000.00	0.00	(35,256,196.92)	(35,156,196.92)
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	(390,947,221.30)	(390,947,221.30)
<b>17</b>	<b>2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл</b>	<b>100,000.00</b>	<b>0.00</b>	<b>(426,203,418.22)</b>	<b>(426,103,418.22)</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>0.00</b>	<b>35,411,436,557.15</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	0.00	35,410,230,060.25
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	0.00	1,206,496.90
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>30,041,146.81</b>	<b>9,235,691,728.27</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	18,657,919.54	997,831,490.64
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	6,650,727.27	255,550,473.66
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	4,632,500.00	21,623,931.50
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	0.00	3,932,104,179.76
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	86,000.00	21,820,887.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	0.00	3,405,752,334.49
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	1,812,612.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	14,000.00	599,195,819.22
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(30,041,146.81)</b>	<b>26,175,744,828.88</b>
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	548,780,026.34
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	0.00	548,780,026.34
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>0.00</b>	<b>165,739,920.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	159,710,920.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	6,029,000.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>0.00</b>	<b>383,040,106.34</b>
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>44,370,390.91</b>	<b>295,056,565.34</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	44,370,390.91	295,056,565.34
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>0.00</b>	<b>23,348,447,865.34</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0.00	23,348,447,865.34
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>44,370,390.91</b>	<b>(23,053,391,300.00)</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>14,329,244.10</b>	<b>3,505,393,635.22</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>70,700.00</b>	<b>14,399,944.10</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>14,399,944.10</b>	<b>3,519,793,579.32</b>

Улаанбаатар энержи ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025гүйц	Хувь	2025 төл/ 2025гүйц	Хувь
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:									
1	Цахилгаан эрчим хүч	м.төг	0.0	32,969,380.4	37,863,738.1	-	-	4,894,357.7	114.8
2	Нийт орлого	м.төг	0.0	32,985,323.9	38,468,436.0	-	-	5,483,112.1	116.6
3	Нийт зардал	м.төг	29,696.4	38,463,617.8	40,001,693.2	39,971,996.8	1,347.0	1,538,075.4	104.0
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	15,914.2	0.0	352,115.6	336,201.4	22.1	352,115.6	0.0
4	Татварын өмнөх ашиг	м.төг	(29,696.4)	(5,478,294.0)	(1,533,257.2)	(1,503,560.8)	51.6	3,945,036.8	28.0
5	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	(29,419.2)	(5,478,294.0)	(390,947.2)	(361,528.0)	13.3	5,087,346.8	7.1
6	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	6,650.7	3,438,164.6	3,661,302.8	3,654,652.1	550.5	223,138.2	106.5
	а/ Орлогын татварт	м.төг	0.0	1,594.3	78,486.0	78,486.0	-	76,891.7	-
	б/ НӨАТ	м.төг	0.0	2,997,216.4	3,327,266.3	3,327,266.3	-	330,049.9	111.0
	в/ НДШ	м.төг	6,650.7	329,813.5	255,550.5	248,899.8	38.4	(74,263.0)	77.5
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	0.0	107,240.0		0.0	-	(107,240.0)	0.0
	з/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	0.0	2,300.4	0.0	0.0	-	(2,300.4)	0.0
8	Нийт ажиллагсадын тоо	хүн	11.0	27.0	23.0	12.0	2.1	(4.0)	85.2
9	Нийт цалингийн сан	м.төг	25,308.6	1,467,022.6	1,105,069.1	1,079,760.5	43.7	(361,953.5)	75.3
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	2,300.8	54,334.2	48,046.5	45,745.7	20.9	(6,287.7)	88.4
11	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	м.төг		1.17	1.04	-	-	(0.1)	89.2
12	Хөрөнгө оруулалт	м.төг				0.0	-	0.0	-
13	<b>Нийт авлага</b>	<b>м.төг</b>	1,035.5	0.0	6,428,071.3	6,427,035.7	6,207.5	6,428,071.3	-
	Үүнээс: Найдваргүй	м.төг	0.0	0.0	0.0	0.0	-	0.0	-
14	<b>Нийт өглөг</b>	<b>м.төг</b>	55,330.4	0.0	286,249,057.1	286,193,726.7	5,173.5	286,249,057.1	-
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	55,330.4	<b>0.0</b>	2,241,441.3	2,186,110.9	40.5	2,241,441.3	-
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	0.0	<b>0.0</b>	284,007,615.8	284,007,615.8	-	284,007,615.8	-

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 286,178,226.9 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

#### Залруулсан алдаа

- Багануур дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламжийн өргөтгөл 50 мвт/200 квт.цаг Багануур батерей хуримтлуурын станцын хөрөнгийг хүлээн авсан 286,151,012.0 мянган төгрөгийг үндсэн хөрөнгөөр зөвшөөрч бүртгээгүйг;
- Валютын ханшны өөрчлөлтийн бодит алдагдал 20,356.6 мянган төгрөгийг удирдлагын зардлаар хүлээн зөвшөөрч буруу бүртгэснийг;
- Санхүүгийн програмын лицензийн төлбөр 1,980.0 мянган төгрөгийг урьдчилж гарсан зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэснийг;
- ХХОАТ-ын тайланд ногдуулалтыг 2,806.0 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд ногдуулалтыг 1,621.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг;
- Албан томилолтын тооцоог бодохдоо НӨАТ-тэй баримт бүрдүүлж, 451.1 мянган төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ыг санхүүгийн тайланд буруу бүртгэснийг;

Эдгээр нь НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 1.27-д “санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой”, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 “иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “*нийцсэн бөгөөд зохистой байх*”, “*үнэн зөв байх*”, “*иж бүрэн байх*”, батламж мэдэгдлийг хангахгүй байгааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасны дагуу залруулга хийлгэж санхүүгийн тайланг баталгаажуулав.

Аудитаар нийт 1,079.5 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>1</sup> илэрснээс, 1,079.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

Нийт залруулагдаагүй 1,079.5 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

#### 3.1 Төлбөрийн акт

1. Албан томилолтоор ажилласан 7 ажилтанд хоолны нөхөн олговрын 180.0 мянган төгрөгийг, 2 ажилтанд илүү цагийн хөлсийг 240,9 мянган төгрөгөөр, 1 ажилтанд цалин нэмэгдлийг 658,6 мянган төгрөгөөр, нийт 1,079.5 мянган төгрөгийг тус тус давхардуулан тооцож илүү олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.  
НТАГ-2026/136/НА-СТА-ОНӨҮГ

зүйлийн 6.4.1-д *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5-д *“Төрийн өөрийн өмчийг зориулалт бусаар захиран зарцуулах, нийгмийн шинжтэй төсөл, арга хэмжээнд зарцуулах, хандив, тусламж, түүнтэй адилтгах хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглох бөгөөд энэхүү хориглолтыг зөрчсөн эрх бүхий этгээдийг албан тушаалаас чөлөөлж, учруулсан хохирлыг нөхөн төлүүлнэ.”* гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “үнэн зөв байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Илүү олгосон хоолны нөхөн олговор, илүү цагийн хөлсийг нөхөн төлүүлж, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Дээрх шилэн дансны хэрэгжилтэд өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Улаанбаатар энерги ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**4.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Д.Д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	220/110/35 кВ-ын Багануур дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламжийн өргөтгөл 50 мвт/200 квт.цаг Багануур батерей хуримтлуурын станцын хөрөнгийг хүлээн авсан 286,151,012.065 төгрөгийг үндсэн хөрөнгөөр зөвшөөрч бүртгээгүй	1	286,151,012.0			1	286,151,012.0	1	286,151,012.0				
2	Валютын ханшны өөрчлөлтийн бодит алдагдал 20,356,609.18 төгрөгийг удирдлагын зардлаар хүлээн зөвшөөрч буруу бүртгэсэн	1	20,356.6			1	20,356.6	1	20,356.6				
3	Санхүүгийн програмын лицензийн төлбөр 1,980,000.00 төгрөгийг урьдчилж гарсан зардлаар хүлээн зөвшөөрч буруу бүртгэсэн	1	1,980.0			1	1,980.0	1	1,980.0				
4	ХХОАТ-ын тайланд ногдуулалтыг 2,805,993.94 төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд ногдуулалтыг 1,621,197.04 төгрөгөөр дутуу тайлагнасан	1	4,427.2			1	4,427.2	1	4,427.2				
5	Албан томилолтын тооцоог бодохдоо неат-тэй баримт бүрдүүлж, 451,128.35 худалдан авалтын НӨАТ-ыг санхүүгийн тайланд буруу бүртгэсэн	1	451,1			1	451,1	1	451,1				
	<b>Дүн</b>	<b>5</b>	<b>286,178,226.9</b>			<b>5</b>	<b>286,178,226.9</b>	<b>5</b>	<b>286,178,226.9</b>				

Улаанбаатар энерги ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

4.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
1	Албан томилолтоор ажилласан 7 ажилтанд хоолны нөхөн олговрын 180.0 мянган төгрөгийг, 2 ажилтанд илүү цагийн хөлсийг 240,9 мянган төгрөгөөр, 1 ажилтанд цалин нэмэгдлийг 658,6 мянган төгрөгөөр, нийт 1,079.5 мянган төгрөгийг тус тус давхардуулан тооцож илүү олгосон байна.	1	1,079.5	1	1,079.5									
	<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1,079.5</b>	<b>1</b>	<b>1,079.5</b>									

4.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
1	Мэдээлбэл зохих 26 төрлийн 157 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг огт мэдээлээгүй	1	-					1	-
	<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>					<b>1</b>	<b>-</b>
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
	<b>Дүн</b>	<b>-</b>	<b>-</b>					<b>-</b>	<b>-</b>
	<b>Нийт дүн</b>	<b>1</b>						<b>1</b>	